ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ХҮҮХДИЙН ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 01 сарын 27 өдөр Дугаар А/05 Бор-Өндөр сум

Арга зүйч Ц.Отгонжаргал хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлыг хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, Монгол улсын хөдөлмөрийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/114 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Арга зүйч Ц.Отгонжаргал 2026 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцах ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, уг ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх мөн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийж ажлыг сайжруулан үр дүнтэй хариуцлагатай ажиллахыг (Ц.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.
3. Арга зүйч Ц.Отгонжаргалд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг 2026 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн үндсэн цалингийн 30 хувиар бодож олгохыг нягтлан бодогч (М.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.АЛЬМАА

1825010070 4216563

Galaxy A15